



ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ :

XX ЗУУНЫ ХУВЬСГАЛУУД

XX зуунд хэдэн удаа хувьсгал хийсэн бэ?

Уг хувьсгалуудыг хэн, хэн удирдаж байв.

Хувьсгалын үр дүнд юу өөрчлөгдөв.



Хичээлийн зорилго



1911, 1921, 1990 оны хувьсгалын шинж чанар, ач холбогдлыг зэрэгцүүлэн тодорхойлох, эдгээр хувьсгалын үр дүнд гарсан өөрчлөлтийг харьцуулах, дүгнэх



Харьцуулан
шинжлэх

Асуудал
дэвшүүлэх

Үндэслэлтэй
тайлбарлах



XX зууны хувьсгалууд



Харьцуулсан шинжилгээ хийж үзье.



Үзүүлэлт	1911	1921	1990
Удирдагчид	VIII Богд Жавзандамба Чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд	Д. Бодоо, С. Данзан, Д. Сүхбаатар	С. Зориг
Хувьсгалын шалтгаан	ШЗБ, Манжийн эрхшээл, Тусгаар тогтнол	1917 Октябрын эргэлт, 1919 Хятадын цэргийн дэглэм	Социализмын мухардал, хямрал,
Гол үйл явдал	1911.12.29	1921. 07.11	1989.12.10
Шинж чанар	Үндэсний эрх чөлөөний хувьсгал	Үндэсний ардчилсан хувьсгал	Ардчилсан хувьсгал
Ач холбогдол	Тусгаар тогтнолоо олж авсан	Тусгаар тогтнолоо сэргээсэн	Ардчилал, чөлөөт зах зээл

Өнгөрсөн түүхтэйгээ тооцоо хийж, улс төржүүлж байгаа ард түмэн бол золгүй ард түмэн. Энэ нь яваандаа мөхөхийн цондон.

Оросын их сэтгэгч Бердеяв



XX зууны хувьсгалууд



Ямар өөрчлөлтүүд гарсан бэ?



Үзүүлэлт	1911	1921	1990
Улс төр	<ul style="list-style-type: none">- Улсын дээд, доод хурал- Жинхэнэ ардын дагаж явах дүрэм- Байнгын цэрэг	<ul style="list-style-type: none">- Ардын засгийн газар- Тангарагийн гэрээ- Хамжлагын харилцаа- Үндсэн хууль	<ul style="list-style-type: none">- Чөлөөт, ардчилсан сонгууль- Үндсэн хууль
Эдийн засаг	<ul style="list-style-type: none">- 1913 онд гаалийн дүрэм- Монголор нийгэмлэг- Худалдаа, арилжаа- МАА, Газар тариалан	<ul style="list-style-type: none">- Хятад, Орос, бусад, (Даашинхүү)- Хоршоо- Татвар- Мөнгөн тэмдэгт	<ul style="list-style-type: none">- Зах зээлийн эдийн засаг- Чөлөөт үнийн тогтолцоо- Өмч хувьчлал
Оюун санаа	<ul style="list-style-type: none">- 1912 оноос албан сургууль,- Шинэ толь, Нийслэл хүрээний сонин бичиг	<ul style="list-style-type: none">- Судар бичгийн хүрээлэн- 1924 Улсын номын сан, Архив- 1924 Ардыг гэгээрүүлэх яам	<ul style="list-style-type: none">- Олон ургальч үзэл- Чөлөөт сэтгэлгээ- Хэвлэл мэдээллийн эрх чөлөө



XX зууны хувьсгалууд



Нэгд, байнгын **хүн ам**: хоёрт, тухайлан заагласан **нутаг дэвсгэр**: гуравт, **төр засаг**: дөрөвт, **бусад улсуудтай харилцаанд орох чадамж**... “бусад улсуудаар хүлээн зөвшөөрөгдсөн байдал нь улсыг тодорхойлох хүчин зүйл болохгүй”
Монтевидеогийн Конвенц 1,3-р зүйлээс



Декларатив зарчим

Аливаа улс нь өөрийн тусгаар тогтнолоо зарлан тунхагласан, өөрийн газар нутаг, хүн ам, төрийн зохион байгуулалт, засаг захиргаатай, бусад улс орнуудтай харилцаанд орох чадамжтай байх зэрэг шалгуурт нийцэж байгаа тохиолдолд тэр улсыг тусгаар тогтносон, олон улсын харилцааны бие даасан субъект гэж тооцдог зарчим

Де факто нь тухайн улсын нутаг дэвсгэр дээр тогтсон засаглал, улс төрийн дэглэмийг нөгөө улсын зүгээс хэсэг хугацаанд тодорхойгүйгээр хүлээн зөвшөөрөх хэлбэр.



XX зууны хувьсгалууд

Декларатив үзэл зарчмын үүднээс авч үзвэл



Тусгаар тогтнолоо
олон улсад
тунхагласан



Хэмжээгүй эрхт
хаант төр



Газар нутаг, хүн ам,
засаг захиргааны
зохион байгуулалт



Бие даан бодлого
шийдвэр гаргаж,
хэрэгжүүлж байсан.



Бусад улс орнуудай
харилцаанд
оролцох чадамжтай
байсан



XX зууны хувьсгалууд



1912 оны 11-р сарын 18-ны өдөр Гадаад Харилцааны Яам Франц, Англи, Герман, АНУ, Бельги, Япон, Дани, Нидерланд, Австри-Унгарын эзэнт гүрний Гадаад хэргийн яаманд захидал илгээсэн.



XX зууны хувьсгалууд

1911 Үндэсний эрх чөлөөний хувьсгал уу, хөдөлгөөн үү?

ХУВЬСГАЛ



1990 оноос хойш



Төрт ёс, тусгаар тогтнол



А. Амар, Л. Дэндэв

ХӨДӨЛГӨӨН



1990 оноос өмнө



Бүрмөсөн шийдвэрлэж чадаагүй



Г. Навааннамжил, Ц.
Пунцагноров



XX зууны хувьсгалууд

1921 оны хувьсгал Үндэсний ардчилсан шинж чанартай байсан уу?

Үндэсний ардчилсан хувьсгал

Шашин, төрийг хослон барьсан хэмжээгүй эрхт хаант засгаас ардын эрхт хэмжээт цаазат хаант засаг, түүнээс Бүгд Найрамдах Засагт дэвшин орсон

Монгол Улс түүхэндээ анх удаа Үндсэн хуультай болсон юм. Энэхүү Үндсэн хуулийн үзэл баримтлалд үндэсний ардчилсан үзэл давамгайлж байлаа.

Анхдугаар Үндсэн хуульд Монгол хүний эрх, эрх чөлөөг анх удаа хуульчлан тунхагласан билээ. Ялангуяа эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдийн нэг адил тэгш эрхтэй хэмээгээд сонгох, сонгогдох эрх олгосон байна

*Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн,
Академич Ж.Болдбаатар*



XX зууны хувьсгалууд



“Монголын асуудал бидэнд их ач холбогдолтой байна. Монголын асуудалд идэвхтэй оролцохгүйгээр ... Тэр хоёрын хооронд зуучлан, Монголоос Чин улстай тогтоосон сюзерений холбоог таслалгүйгээр үндэсний байдлаа хамгаалах гэсэн монголчуудын эрмэлзлэлийг дипломат замаар дэмжинэ”
Монголын тухай онц зөвлөгөөн



БНМАУ нь Хятадын суверенитийн дор автономи байх хэлбэрийг бид тунхаглах боловч хэрэг дээрээ улс төр, эдийн засгийн байгууллын хувьд Монголыг Зөвлөлт маягийн хэлбэрт оруулахыг хичээн ажиллана.

Г. В. Чичеринээс Монгол дахь бүрэн эрхт төлөөлөгч Никифоровт өгсөн заавраас



“Монголын нутаг дэвсгэр Англи, Герман, Францыг нийлүүлснээс өргөн уудам, хүн ам нь дөнгөж 800 мянга, энэ нутаг дэвсгэрт бид нөлөөгөө хадгалж, ... Дайсны нөлөөнд оруулахгүй байхыг бусармаг аргаар ч болов хичээх нь манай зорилт мөн.”

Б. Шмераль



XX зууны хувьсгалууд



Монголын талын зорилго



- Эрх чөлөө, тусгаар тогтнолоо эргүүлэн олж авах
- Төр ёс, түүхэн уламжлал, улс үндэснийхээ онцлогийг хадгалан хөгжих
- Дэлхий дахины ололт амжилт, туршлагыг харгалзан үзэх
- Дотоодын эв нэгдэл, хамтын хүч, ардчилсан өөрчлөлт,
- ЗОУ болон бусад улс гүрнээс тусламж авах

ЗОУ-ын талын сонирхол



- Монголыг өөрийн нөлөөний хүрээнээс алдахгүй байх
- Монгол дахь өөрийн эрх ашиг, байр суурийг бэхжүүлэхэд ашиглах
- Цагаантнуудын орогнох, хүчээ сэлбэх нэг газар нь Монгол байсан тул тэдний хүчийг дайсан этгээдийнхээ эсрэг тэмцэлд ашиглах
- Өөрийн үзэл суртлыг түгээн дэлгэрүүлэх
- Монголд Зөвлөлт маягийн дэглэм тогтоож, өөрийн дуулгавартай холбоотой, дагуул улс болгох



XX зууны хувьсгалууд



Ардчилсан хувьсгал уу, Ардчилсан шинэчлэл үү?



Хуучин байдлыг эрс өөрчилж, шинэ дэг ёс тогтоон хөгжих үйл явцыг **хувьсгал** гэж хэлдэг түгээмэл хандлага байна.



1990 оны цагаан морин жил Монголд өрнөсөн түүхэн үйл явдлыг “**хувьсгал**” гэж тодорхойлох бодит боломжийг уг үйл явдлын үр дүн олгодог.

Төр засаглалын ардчилсан тогтолцоо

Зах зээлийн эдийн засаг

Олон ургальч үзэл

Шүтэх эс шүтэх



XX зууны хувьсгалууд



Монголын тусгаар тогтнолтой холбоотой зарим чухал гэрээ хэлэлцээрүүд





ГЭРИЙН ДААЛГАВАР



Даалгаврын
хувилбарууд

Эрдэм шинжилгээний өгүүлэл уншиж, түүнийгээ
тайлбарлах



1911, 1921, 1990 хувьсгалын сонирхсон асуудлын
хүрээнд бүтээлч даалгавар хийгээрэй.

Хэд хэдэн эх сурвалжийг харьцуулж, дүгнэх



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА